

ХОТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ 20 . . . ОНЫ ЖИЛИЙН МЭДЭЭ

Аймаг, нийслэл

Сум, дүүрэг

1. Сум, дүүргийн ЗДТГ болон тухайн чиглэлийн аж ахуйн нэгж, байгууллагууд жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газарт маягтаар ирүүлэх;
2. Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газар нь жил бүрийн 1 дүгээр сарын 21-нд Үндэсний статистикийн хороонд цахим хэлбэрээр ирүүлнэ.

		Мөрийн дугаар	Хэмжих нэгж	Гүйцэтгэл
		Б	В	1
Ус хангамж	Цэвэр усны өргөх станц	1	тоо	
	Цэвэр усны өргөх станцын хүчин чадал	2	м ³ /хоног	
	Усан сан	3	тоо	
	Ундны ус түгээх байр	4	тоо	
	Ундны усны гүний худаг	5	тоо	
	Ундны усны энгийн гар худаг	6	тоо	
	Ундны ус тээврийн машин	7	тоо	
	Түгээсэн ундны усны жилийн нийт хэмжээ	8	мян.м ³	
	Зөөврийн ундны ус хэрэглэдэг өрх	9	тоо	
	Баталгаат ундны усны хангамжгүй өрх	10	тоо	
	Бохир усны өргөх станц	11	тоо	
	Бохир усны өргөх станцын хүчин чадал	12	м ³ /хоног	
	Бохир усны цооног	13	тоо	
	Зайлуулсан бохир усны хэмжээ	14	мян.м ³	
Сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй өрх		15	тоо	
Хог хаягдал, зайлуулалт	Хог устгалын цэг	16	тоо	
	Хог тээврийн машин	17	тоо	
	Тээвэрлэсэн хуурай хог хаягдлын хэмжээ	18	мян.м ³	
	Үүнээс: Хүн амаас /орон сууц болон гэр хорооллоос/ Байнгын цэвэрлэгээтэй талбайн хэмжээ	19	мян.м ³	
Халуун усны үйлчилгээ	Халуун усны газар	21	тоо	
	Үүнээс: Саунтай	22	тоо	
	Халуун усны газрын багтаамж	23	хүн	
	Үүнээс: Саунтай	24	хүн	
Бассейн		25	тоо	
Тохижуулсан талбай	Гэрэлтүүлэгтэй гудамж	26	км	
	Цэцэрлэгт хүрээлэн	27	тоо	
	Усан оргилуур	28	тоо	
	Хүүхдийн тоглоомын талбай	29	тоо	
	Хөшөө, баримал	30	тоо	

Тамга тэмдэг

Сум, дүүргийн Засаг дарга /

/

**Хот, нийтийн аж ахуйн үйлчилгээний жилийн мэдээний
маягт НҮ-1 -г нөхөх заавар**

1,2-р мөрөнд: Цэвэр усны өргөх станц гэдэгт хот, сууринг цэвэр усаар хангах зорилгоор бусад ус хангамжийн эх үүсвэрээс тусгай саванд татан хуримтлуулж, ариутгах насос/шахуургын тусламжтайгаар төвлөрсөн шугамаар хэрэглэгчдэд түгээх зориулалт бүхий инженерийн барилга, байгууламжийг хамруулах бөгөөд түүний хүчин чадлыг хэрэглэгчдэд хоногт түгээж буй усны хэмжээгээр тодорхойлно. Түгээж буй усны хэмжээг куб метрээр илэрхийлж бичнэ.

3-р мөрөнд: Усан сан гэдэгт усыг хуримтлуулан ашиглах зориулалтаар баригдсан усны барилга, байгууламж, хиймэл нуур, цөөрмийг хамруулна /Усны тухай Монгол Улсын хуулийн 3-р зүйлийн 1-р заалт/.

4-р мөрөнд: Ундны ус түгээх байр гэдэгт усан сангийн усыг хэрэглэгчдэд түгээж буй байрыг хамруулна.

5-р мөрөнд: Ундны усны гүний худаг буюу инженерийн хийцтэй худагт газрын доорхи усыг авч ашиглах зорилгоор газрын гүний уст үед байрлуулсан ус шүүж оруулах шүүртэй, дотор талдаа усны шахуурга, ус дамжуулах хоолойтой инженерийн байгууламжийг хамруулна. Мөн гүний шахуургатай, байнгын орон тооны хүн ажилладаг худгийг оруулна.

6-р мөрөнд: Гар худагт хөрсний өнгөн хэсэгт ус байх магадлал бүхий газарт гараар ухаж гаргасан, ханыг нь мод, чулуу зэрэг материалаар хашиж бэхэлсэн энгийн худгийг хамруулна.

7-р мөрөнд: Ундны ус тээврийн машин гэдэгт сум, дүүрэг болон харьяа байгууллагуудаас зөвшөөрөл олгосон, ундны ус тээвэрлэж буй машиныг хамруулна.

8-р мөрөнд: Усан сангаас тээврийн машинаар ундны ус түгээх цэгүүдэд түгээсэн усны жилийн нийт хэмжээг мянган куб метрээр илэрхийлж бичнэ.

9-р мөрөнд: Зөөврийн ундны ус хэрэглэдэг өрхөд төвлөрсөн шугамд холбогдоогүй, ус түгээх байр, ус тээврийн машин, ердийн хөсөг болон хамгаалагдсан булаг, шанднаас ундны усыг авч хэрэглэхгүй байгаа өрхүүдийг хамруулна.

10-р мөрөнд: Баталгаат ундны усны хангамжгүй өрхөд гол, мөрөн, хамгаалалтгүй булаг, шандаас ундны усаа авч хэрэглэж буй өрхүүдийг хамруулна.

11,12-р мөрөнд: Бохир усны өргөх станц гэдэгт бохир усыг өөрийн урсгалаар нэвтрүүлэх боломжгүй тохиолдолд бохирыг зайлуулах зориулалттай насос тоноглол бүхий инженерийн барилга байгууламжийг хамруулах түүний хүчин чадлыг нь хоногт цэвэршүүлж буй бохирын хэмжээгээр тодорхойлно. Цэвэршүүлж буй бохирын хэмжээг куб метрээр илэрхийлэнэ.

13-р мөрөнд: Бохир усны цооног гэдэгт хэрэглээнээс гарсан бохир усыг хуримтлуулж, цэвэрлэх зориулалт бүхий төхөөрөмжид дамжуулах зориулалттай, төвлөрсөн шугамд холбогдоогүй байгууламжийг хамруулна.

14-р мөрөнд: Иргэд болон аж ахуйн нэгж байгууллагаас бохирын шугамаар дамжуулж зайлуулсан бохир усны хэмжээг мянган куб метрээр илэрхийлж бичнэ.

15-р мөр: Сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй өрхөд бохирыг хөрсөнд нэвчүүлэх зориулалт, ялгадас зайлуулах эрүүл ахуйн шаардлага хангаагүй нүхэн жорлонтой өрхийг хамруулна.

16-р мөрөнд: Хог устгах цэгийн тоонд сум, дүүргээс тогтоосон газарт зөвөөрлөж, тээвэрлэсэн хог хаягдлыг устгах үндсэн цэгүүд хамаарна.

17-р мөрөнд: Хог тээврийн машинд сум, дүүрэг болон харьяа байгууллагуудаас хог тээвэрлэх зөвшөөрөл олгосон машиныг хамруулна.

18, 19-р мөрөнд: Хог тээврийн машинаар хог устгалын цэгт тээвэрлэсэн хог хаягдлын хэмжээг мянган куб метрээр, үүнээс орон сууц болон гэр хорооллоос тээвэрлэсэн хог хаягдлын хэмжээг салган мянган куб метрээр илэрхийлж бичнэ.

20-р мөрөнд: Нийтийн эзэмшлийн зам талбайн байнгын цэвэрлэгээтэй хэсгийг мянган куб метрээр илэрхийлж бичнэ.

21-24-р мөрөнд: Тухайн жилд үйл ажиллагаа явуулсан, бие даан санхүүгийн тайлан тэнцэл гаргадаг эсэхээс үл хамаарч өмчийн бүх хэлбэрийн халуун усны газрыг хамруулна. Саунтай, халуун усны газарт халуун агаар болон уурын ваннаар тоноглогдсон өрөө, тасалгаатай халуун усны газрыг хамруулна. Халуун усны газрын багтаамжийг нэг удаа нэгэн зэрэг орох хүний тоогоор илэрхийлэнэ.

25-р мөрөнд: Бассейнд хүн амын бие бялдарыг чийрэгжүүлэх усан спортоор хичээллэх нөхцөлийг хангасан нийтийн хэрэглээний зориулалт бүхий байгууламжийг хамруулна.

26-р мөрөнд: Гэрэлтүүлэгтэй гудамжийн хэмжээг гаргахдаа нийтийн эзэмшлийн авто зам, гудамж, цэцэрлэгт хүрээлэнд тавигдсан гэрэлтүүлийн уртыг километрээр илэрхийлж бичнэ.

27-30-р мөрөнд: Нийтийн эзэмшилд зориулж байгуулсан цэцэрлэгт хүрээлэн, усан оргилуур, хүүхдийн тоглоомын талбай, хөшөө дурсгал, баримлын тоог бичнэ.